

# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: УВА-2026/075/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Т.Амармэнд

Утас: 70453799, Цахим хаяг: amarmendt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

### **1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

### **2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
  - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
  - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
  - 3.5.3 Нэмэлт төсөв

### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
  - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
  - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
  - 4.5.1 Завсрын аудитын талаар
  - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

### **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

#### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

**БӨХМӨРӨН СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Б.ВАНЧИНХҮҮ  
ТАНАА**

2026. 09.23 № УВА-0026/075/МА-СГА-ТМЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

### **Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050465

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>324,947,420.38</b>	<b>181,078,982.42</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>157,275,638.73</b>	<b>23,888,265.55</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>157,275,638.73</b>	<b>23,888,265.55</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>157,275,638.73</b>	<b>23,888,265.55</b>
31211	Төрийн сангийн харилцах	157,275,638.73	23,888,265.55
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>25,572,655.80</b>	<b>26,239,885.80</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	667,230.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>25,572,655.80</b>	<b>25,572,655.80</b>
3352	Хувь хүмүүсээс авах авлага	25,572,655.80	25,572,655.80
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>142,099,125.85</b>	<b>130,950,831.07</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>142,099,125.85</b>	<b>130,950,831.07</b>
35410	Бичиг хэргийн материал	19,320,989.32	20,489,791.32
35420	Аж ахуйн материал	85,236,966.28	73,051,506.28
35430	Сэлбэг хэрэгсэл	200,000.00	200,000.00
35460	Хүнсний материал	4,242,480.00	1,975,000.00
35470	Бусад хангамжийн материал	33,098,690.25	35,234,533.47
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,593,680,465.56</b>	<b>2,579,705,550.32</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,593,680,465.56</b>	<b>2,579,705,550.32</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,511,432,465.56</b>	<b>2,489,185,550.32</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,431,950,955.00	2,431,950,955.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-337,507,723.18	-397,938,138.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	32,500,000.00	32,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-31,145,833.41	-32,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	520,669,275.06	529,781,452.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	-245,233,668.48	-295,004,395.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	262,122,166.65	331,894,031.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	-151,865,855.21	-141,441,503.01
39217	Ном	29,943,149.13	29,943,149.13
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>82,248,000.00</b>	<b>90,520,000.00</b>
39301	Программ хангамж	440,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-440,000.00	-440,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	82,248,000.00	90,520,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,918,627,885.94</b>	<b>2,760,784,532.74</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>51,981,684.00</b>	<b>34,296,242.66</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>51,981,684.00</b>	<b>34,296,242.66</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>51,981,684.00</b>	<b>34,296,242.66</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	667,230.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	46,538,784.00	32,593,282.66
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>5,442,900.00</b>	<b>1,035,730.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	5,442,900.00	1,035,730.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,866,646,201.94</b>	<b>2,726,488,290.08</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,866,646,201.94</b>	<b>2,726,488,290.08</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	820,075,316.80	820,075,316.80
51101	Өмч: - төрийн	820,075,316.80	820,075,316.80
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,702,911,972.59</b>	<b>1,563,024,289.90</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,702,911,972.59	1,703,182,201.76
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-140,157,911.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	343,658,912.55	343,388,683.38
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,918,627,885.94</b>	<b>2,760,784,532.74</b>

## 2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,215,542,701.98</b>	<b>2,298,911,558.57</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>231,881,201.98</b>	<b>160,948,058.57</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	231,881,201.98	160,948,058.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,921,100.00	62,239,463.35
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,921,100.00	2,324,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	59,914,563.35
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,983,661,500.00</b>	<b>2,137,963,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,760,296,500.00	1,930,341,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,760,296,500.00	1,930,341,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	22,137,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	22,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	137,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	223,365,000.00	185,484,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	223,365,000.00	185,484,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,032,504,872.34</b>	<b>2,436,441,544.87</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,032,504,872.34</b>	<b>2,436,441,544.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,967,069,818.09	2,346,574,094.87
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,299,144,713.00	1,567,068,959.00
210101	Үндсэн цалин	802,934,410.00	887,306,579.00
210102	Нэмэгдэл	418,076,498.00	516,503,454.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	43,372,800.00
210104	Урамшуулал	78,133,805.00	119,886,126.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	161,892,614.24	194,108,293.75
210201	Тэтгэврийн даатгал	109,703,159.56	133,010,844.04
210202	Тэтгэмжийн даатгал	12,977,483.09	15,742,389.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,056,257.44	8,574,877.28
210204	Ажилгүйдлийн даатгал	6,231,144.85	7,356,037.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,924,569.30	29,424,145.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	265,648,269.75	225,213,118.01
210301	Гэрэл, цахилгаан	15,091,245.68	21,194,877.94
210302	Түлш, халаалт	250,557,024.07	204,018,240.07
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,210,800.00	45,914,284.00
210401	Бичиг хэрэг	1,292,850.00	1,696,050.00
210402	Тээвэр, шатахуун	8,672,000.00	17,903,574.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,659,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,586,950.00	9,889,600.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	16,425,060.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	81,001,632.00	110,742,830.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	330,500.00	00.00
210502	Хоол, хүнс	80,671,132.00	110,742,830.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,801,500.00</b>	<b>8,166,000.00</b>
210604	Урсгал засвар	2,801,500.00	8,166,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,266,000.00</b>	<b>1,530,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,266,000.00	1,530,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,317,058.84</b>	<b>23,055,570.43</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,574,400.00	2,714,644.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	806,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,500.00	55,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,258,958.84	19,479,526.43
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>122,787,230.26</b>	<b>170,775,039.68</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,670,400.00	22,349,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,040,750.00	7,715,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	111,076,080.26	140,710,289.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>65,435,054.25</b>	<b>89,867,450.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>64,154,040.00</b>	<b>89,867,450.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	45,161,790.00	70,919,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,992,250.00	18,947,700.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,281,014.25</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,281,014.25	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>183,037,829.64</b>	<b>-137,529,986.30</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>2,627,925.56</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,627,925.56
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-2,627,925.56</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>183,037,829.64</b>	<b>-140,157,911.86</b>

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,985,582,600.00</b>	<b>2,140,288,400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,921,100.00</b>	<b>2,324,900.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,921,100.00</b>	<b>2,324,900.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,921,100.00	2,324,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,921,100.00	2,324,900.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,983,661,500.00</b>	<b>2,137,963,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,760,296,500.00</b>	<b>1,930,341,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,760,296,500.00	1,930,341,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00.00</b>	<b>22,137,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	22,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	137,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>223,365,000.00</b>	<b>185,484,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	223,365,000.00	185,484,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,910,211,168.08</b>	<b>2,240,578,473.18</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,910,211,168.08</b>	<b>2,240,578,473.18</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,848,107,733.83</b>	<b>2,152,622,473.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,299,144,713.00</b>	<b>1,567,068,959.00</b>
210101	Үндсэн цалин	802,934,410.00	887,306,579.00
210102	Нэмэгдэл	418,076,498.00	516,503,454.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	43,372,800.00
210104	Урамшуулал	78,133,805.00	119,886,126.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>161,892,614.24</b>	<b>194,108,293.75</b>
210201	Тэтгэврийн даатгал	109,703,159.56	133,010,844.04
210202	Тэтгэмжийн даатгал	12,977,483.09	15,742,389.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,056,257.44	8,574,877.28
210204	Ажилгүйдлийн даатгал	6,231,144.85	7,356,037.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,924,569.30	29,424,145.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>219,109,485.75</b>	<b>179,634,700.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,091,245.68	21,194,877.94
210302	Түлш, халаалт	204,018,240.07	158,439,822.06
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>81,423,162.00</b>	<b>108,978,070.00</b>
210502	Хоол, хүнс	81,423,162.00	108,978,070.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,974,500.00</b>	<b>5,850,000.00</b>
210604	Урсгал засвар	2,974,500.00	5,850,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,427,358.84</b>	<b>21,684,776.43</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,979,400.00	1,825,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,447,958.84	19,859,776.43
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>70,135,900.00</b>	<b>75,297,674.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,084,400.00	67,531,974.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,051,500.00	7,765,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>62,103,434.25</b>	<b>87,956,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>60,822,420.00</b>	<b>87,956,000.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,263,720.00	69,381,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,558,700.00	18,574,700.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,281,014.25</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,281,014.25	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>75,371,431.92</b>	<b>-100,290,073.18</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>33,097,300.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>33,097,300.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>33,097,300.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	33,097,300.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-33,097,300.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>75,371,431.92</b>	<b>-133,387,373.18</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>81,904,206.81</b>	<b>157,275,638.73</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>157,275,638.73</b>	<b>23,888,265.55</b>

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/төгрөгөөр/
						Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	758,477,316.80	626,728,956.32	295,883,490.50	00.00	1,681,089,763.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	30,048.00	00.00	30,048.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	758,477,316.80	626,728,956.32	295,913,538.50	00.00	1,681,119,811.62
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-30,048.00	00.00	00.00	-30,048.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,144,635.82	00.00	-8,144,635.82
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	820,075,316.80	343,658,912.55	1,702,911,972.59	00.00	2,866,646,201.94
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	820,075,316.80	343,658,912.55	1,702,911,972.59	00.00	2,866,646,201.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	270,229.17	00.00	270,229.17
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	820,075,316.80	343,658,912.55	1,703,182,201.76	00.00	2,866,916,431.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-270,229.17	00.00	00.00	-270,229.17
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-140,157,911.86	00.00	-140,157,911.86
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	820,075,316.80	343,388,683.38	1,563,024,289.90	00.00	2,726,488,290.08

## 2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,157,877,100.00	2,088,191,073.18	69,686,026.82	96.8%
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,157,877,100.00	2,088,191,073.18	69,686,026.82	96.8%
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,066,497,800.00	2,000,235,073.18	66,262,726.82	96.8%
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,605,876,600.00	1,567,068,959.00	38,807,641.00	97.6%
210101	Үндсэн цалин	973,464,600.00	887,306,579.00	86,158,021.00	91.1%
210102	Нэмэгдэл	549,413,100.00	516,503,454.00	32,909,646.00	94.0%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	43,372,800.00	-43,372,800.00	
210104	Урамшуулал	82,998,900.00	119,886,126.00	-36,887,226.00	144.4%
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	199,058,800.00	194,108,293.75	4,950,506.25	97.5%
210201	Тэтгэврийн даатгал	134,780,300.00	133,010,844.04	1,769,455.96	98.7%
210202	Тэтгэмжийн даатгал	16,069,600.00	15,742,389.85	327,210.15	98.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,034,800.00	8,574,877.28	-540,077.28	106.7%
210204	Ажилгүйдлийн даатгал	8,034,800.00	7,356,037.00	678,763.00	91.6%
210205	Эрүүл мэндийн даатгал	32,139,300.00	29,424,145.58	2,715,154.42	91.6%
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	127,746,500.00	108,978,070.00	18,768,430.00	85.3%
210502	Хоол, хүнс	127,746,500.00	108,978,070.00	18,768,430.00	85.3%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	29,438,500.00	29,384,776.43	53,723.57	99.8%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,825,000.00	1,825,000.00	00.00	100.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	27,613,500.00	27,559,776.43	53,723.57	99.8%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	104377400.00	100694974.00	3,682,426.00	96.5%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	96,562,000.00	92,929,274.00	3,632,726.00	96.2%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,815,400.00	7,765,700.00	49,700.00	99.4%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	91379300.00	87956000.00	3,423,300.00	96.3%
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	91,379,300.00	87,956,000.00	3,423,300.00	96.3%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	72,804,600.00	69,381,300.00	3,423,300.00	95.3%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,574,700.00	18,574,700.00	00.00	100.0%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,157,877,100.00	1,954,803,700.00	203,073,400.00	90.6%
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,977,591,600.00	1,930,341,800.00	47,249,800.00	97.6%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,977,591,600.00	1,930,341,800.00	47,249,800.00	97.6%
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	156,915,500.00	2,324,900.00	154,590,600.00	1.5%
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,825,000.00	2,324,900.00	-499,900.00	127.4%
1E+06	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	155,090,500.00	00.00	155,090,500.00	0.0%
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	157,275,638.73	157,275,638.73	-

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	23,888,265.55	-23,888,265.55	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	00.00	100.0%
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	00.00	100.0%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	49.00	48.00	01.00	98.0%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	35.00	34.00	01.00	97.1%
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	00.00	100.0%
620004	Гэрээт ажилтан	02.00	02.00	00.00	100.0%

## 2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	186,506,700.00	185,484,700.00	1,022,000.00	99.5%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	186,506,700.00	185,484,700.00	1,022,000.00	99.5%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	186,506,700.00	185,484,700.00	1,022,000.00	99.5%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	180,656,700.00	179,634,700.00	1,022,000.00	99.4%
210301	Гэрэл, цахилгаан	20,535,800.00	21,194,877.94	-659,077.94	103.2%
210302	Түлш, халаалт	159,098,900.00	158,439,822.06	659,077.94	99.6%
210303	Цэвэр, бохир ус	1,022,000.00		1,022,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,850,000.00	5,850,000.00	0.00	100%
210604	Урсгал засвар	5,850,000.00	5,850,000.00	0.00	100%
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	185,484,700.00	185,484,700.00	0.00	100%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	185,484,700.00	185,484,700.00	0.00	100%
132001	Орон нутгийн төсвөөс	185,484,700.00	185,484,700.00	0.00	100%
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд бага дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих ажлыг мэргэжлийн болон захиргааны удирдлагаар ханган ажиллаж, сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг явуулсан байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 157,843.4 мянган төгрөгөөр буюу 5.4 хувиар буурсан байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	157,275.6	23,888.3	133,387.3
Авлага	25,572.7	26,239.9	667.2
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	142,099.1	130,950.8	-11,148.3
Үндсэн хөрөнгө	2,593,680.5	2,579,705.5	-13,975.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,918,627.9</b>	<b>2,760,784.5</b>	<b>-157,843.4</b>
Өр төлбөр	51,981.7	34,296.2	-17,685.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,866,646.2	2,726,488.3	-140,157.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,918,627.9</b>	<b>2,760,784.5</b>	<b>-157,843.4</b>

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь 2024 онд 157,275.6 мянган төгрөг байсан бол 2025 онд 23,888.3 мянган төгрөг болж буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 26,239.9 мянган төгрөг болж 667.2 мянган төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбогдсон авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 130,950.8 мянган төгрөг болж 11,148.3 мянган төгрөгөөр буурсан тайлант оны худалдан авалт болон 16,425.1 мянган төгрөгийн аж ахуйн материал акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 2,760,784.5 мянган төгрөг болж 157,843.4 мянган төгрөгөөр өссөн буурсан нь төсвийн хөрөнгөөр 33,097.3 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 96,266.0 мянга, тайлант онд 140,710.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцож, 42,207.3 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 34,296.2 мянган төгрөг болж 17,685.5 мянган төгрөгөөр буурсан нь түлш халаалтын өр төлбөр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,726,488.3 мянган төгрөг болж 140,157.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,870,521.9 мянга, орон нутгийн төсвөөс 231,204.0 мянга, нийт 2,101,725.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг хүргүүлсэн саналаар нь баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг улсын төсвөөс 287,355.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, орон нутгийн төсвөөс 45,719.3 мянган төгрөгөөр бууруулан тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,157,877.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 185,484.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,008,191.1 мянган төгрөг буюу 96.8 хувьтай байна. Тогтмол зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 1,022.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт

буцаан төвлөрүүлсэн мөн улсын төсвийн дансны мөнгөн хөрөнгө 23,888.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ /80226/	2,154.2	2,154.2	0.0	100.0%
2	Хүүхэд хамгаалал /80233/	2,215.1	2,076.1	139.0	93.7%
3	Сургалт семинар /80312/	1,265.1	1,265.1	0.0	100.0%
4	Эрүүл мэндийг дэмжих /81605/	3,007.8	907.0	2,100.8	69.8%
5	Үдийн цай хөтөлбөр /81801/	72,804.6	69,381.3	3,423.3	95.3%
6	Дотуур байрны үйлчилгээ /81806/	472,704.5	418,327.8	54,376.7	88.5%
7	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин /81816/	30,797.5	30,797.5	0.0	100.0%
8	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх/81823/	8,438.5	8,438.5	0.0	100.0%
9	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр /81827/	14,055.0	12,536.4	1,518.6	89.2%
10	Боловсролын стандарт, сургалтын хэвийн үйл ажиллагаа /81834/	1,401,771.5	1,401,771.3	0.2	100.0%
11	Сургалтын хэвийн үйл ажиллагаа /81835/	113,220.1	106,516.4	6,703.7	94.1%
12	Сурах бичгийн түрээс /81848/	1,825.0	1,825.0	0.0	100.0%
13	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх /81875/	10,248.2	10,194.5	53.7	99.5%
14	ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан /83602/	22,000.0	22,000.0	0.0	100.0%
15	Нэмэлт- Дээд шатны төсвөөс хуваарилсан /83603/	1,370.0		1,370.0	
16	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал /80111/	186,506.7	185,484.7	1,022.0	99.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5, 2.6-д харуулав.

**Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн**

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	440.0	Үйл ажиллагаандаа санхүүгийн Acoluos программ ашиглаж байгаа бөгөөд тайланд онд 572.0 мянган төгрөгийн зардал гарсан байна
2	Унаа, хоолны зардал	43,372.8	2025 онд 43,372.8 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна.

3	Сургалт, семинар	9,610.0	Үндэсний болон орон нутгийн төрөлжсөн сургалт, мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагаа багш нарыг чадавхжуулах сургалтын зардал гарсан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	-	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	-	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Хэвлэл мэдээлэл	-	Хэвлэл мэдээллийн арга хэмжээнд зардал гараагүй байна.
7	Орон тоо	1,567,069.0	Увс аймгийн Бөхмөрөн сумын сургууль нь 2025 онд 49 орон тоо ажиллахаар батлагдсанаас 49 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотуур байрны үдийн хоолны 2 тендер худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна. Үүнд: Бага ангийн сурагчдын үдийн хоол 83,750.8 мянган төгрөг, дотуур байрны хүүхдийн хоол 171,136.8 мянган төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулан шалгарсан компанитай гэрээ байгуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовн дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 2,032,504.9 мянган төгрөгийн 1 хувиар буюу 20,325.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,436,441.5 мянган төгрөгийн 1 хувиар буюу 24,364.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 19,491.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаандаа оруулсан 175, хугацаа хоцроон байршуулсан 6, мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**







## УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 01/04/2020413  
УБА-2026/075/НА-СТА-ТМЗ

Улаангом

### Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч өөрийн ээлжийн амралтыг тооцоолохдоо Цэцэрлэгийн нягтлан бодогчийг хавсран ажилласан цалинг оруулан тооцож 1,829,442 төгрөгийг илүү авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин олгох журмын 3.3-д “Ээлжийн амралтын цалин бодох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал багтана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3 дахь заалтад “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Илүү олгосон ээлжийн амралтын цалин 1,829,442 /Нэг сая найман зуун хорин есөн мянга дөрвөн зуун дөчин хоёр/ төгрөгийг Бөхмөрөн сумын Ерөнхий

боловсролын сургуулийн нягтлан бодогч Л.Чимгээгээр төлүүлж МХГ-ын орлогын 100150000982 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бөхмөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Б.Ванчинхүү, нягтлан бодогч Л.Чимгээ нарт хариуцуулав.
3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР



Т.АМАРМЭНД

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ